

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО,
ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТОЛЦОО НЬ САЙН
ЗАСАГЛАЛЫГ БИЙ БОЛГОХОД ЧИГЛЭСЭН ЗОРИЛТДОО ХҮРЧ
ЧАДААГҮЙ БАЙНА.

АУДИТЫН КОД: ГСА-2024/19-6-ШТА-ГА

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа,
Утас: 70543156
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр, Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дарханбат, Утас: 70543179
Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дарханбат, Утас: 70543179
Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn

Говьсүмбэр аймаг

2024

Энэхүү аудитын тайлангаар холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа

Аудитын менежер
Г.Наранбаяр

Ахлах аудитор
Б.Дарханбат

Аудитор

С.Батцэцэг

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70543156, 70543179
дугаарын утсаар харилцана
уу.

ХАЯГ:

Сүмбэр сум 3-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 205 тоот

2024 оны 11 дүгээр сар

Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, хууль эрх зүйг
хэрэгжүүлэх тогтолцоо бүрэн бүрдээгүй байна. 8

1.1 Говьсүмбэр аймгийн төрийн байгууллагуудын үйл ажиллагааны
стратеги, зохион байгуулалтын бүтэц нь урт, дунд хугацааны бодлогын
зорилтыг хангахад чиглэгдсэн байна. 8

1.2 Төрийн байгууллагын хүний нөөцийн хүрэлцээгүй байдал нь төрийн
үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлж байна. 9

1.3 Томилох эрх бүхий албан тушаалтнууд 4 албан тушаалд сул орон
тооны зарыг тухай бүр хүргүүлээгүй, хуульд заасан шалгуурыг
хангаагүй 4 хууль бус томилгоо хийсэн байна. 12

Төрийн байгууллагын хүний нөөцийн тогтолцоо сайн засаглалыг
дэмжихэд чиглэгдсэн боловч зорилтдоо хүрч чадаагүй байна. 17

2.1. Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх үр дүнтэй тогтолцоо
бүрдээгүй байна. 17

2.2. Иргэд төрийн үйлчилгээг орон зайнаас үл хамааран цахимаар авах
нөхцөл боломж бүрдсэн байна. 19

2.3. Төрийн байгууллагаас гаргаж буй зарим шийдвэрүүд нь уялдаа
холбоогүй байна. 20

Дүгнэлт

Зөвлөмж

Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Тайлан баталгаажуулах тушаал

Тайлангийн хавсралтууд

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗДҮАХ	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
АТТ	Албан тушаалын тодорхойлолт
ГСА	Говьсүмбэр аймаг
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЗЗНДНТУТХ	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
МЭГ	Мал эмнэлгийн газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТАСЗ	Төрийн албаны салбар зөвлөл
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч
ТЗ	Төрийн захиргаа
ТЗУХ	Төрийн захиргаа удирдлагын хэлтэс
ТТ	Төрийн тусгай
ТУТ	Төрийн улс төр
ТҮ	Төрийн үйлчилгээ
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХЧТА	Хөдөлмөрийн чадвар түр алдалт
ХШҮ	Хяналт шинжилгээ үнэлгээ
ХЭЗХ	Хууль эрх зүйн хэлтэс
ЦСҮТ ОНӨҮГ	Цөм сүргийн үржлийн төв орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ШТА	Шууд тайлагнах аудит
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ШШХ	Шүүхийн шинжилгээний хэлтэс
ЭМТ	Эрүүл мэндийн төв

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл,
бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/162 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг тус тус үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, үр дүнг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Үүнд:

1. Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, хууль эрх зүйг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдсэн эсэх
2. Төрийн байгууллагуудын хүний нөөцийн тогтолцоо нь сайн засаглалыг бий болгож байгаа эсэх

Аудитын хамарсан
хүрээ:

Аймгийн ТЕЗ-д хамаардаг Төрийн албаны тухай хуульд тодорхойлсон төрийн алба, төрийн албан хаагчид болон Төрийн Албаны Зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь Салбар Зөвлөлийн үйл ажиллагаа, гүйцэтгэл, төрийн байгууллагуудын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөөг аудитад хамруулсан. Аудитын судалгаанд төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудыг аудитын цаг хугацаа, хүний нөөцийн хязгаарлагдмал байдал, шалгагдагч байгууллагууд нууцын зэрэглэлтэй зэрэг шалтгаанаар хамруулаагүй болно.

Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглав.

- Төрийн албаны тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Байгууллагын нууцын тухай хууль
- Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
- Засгийн газрын агентлагийн тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын Их Хурлын 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”
- Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”
- Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”

Аудитын арга зүй:

- Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”
- Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, төрийн албан зөвлөлийн даргын 2019 оны 34/31 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-
- Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудит, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, аудитор С.Батцэцэг нар хийж гүйцэтгэлээ.

Хүндрэл бэрхшээл:


Аудитын нээлтийг 2024 оны 09 дүгээр сарын 17-нд хийж, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрөөс 11 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 11 дүгээр сарын 18-ны дотор боловсруулан, дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж холбогдох байгууллага албан тушаалтанд 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр хүргүүлээ.

Нэгдсэн судалгааны маягт 2012-2024 оныг хамарсан байсан бөгөөд холбогдох албан тушаалтнууд олон дахин солигдсон, архивд баримт материал олдохгүй байх, Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичиг аудитын нээлт хийсний дараагаар солигдсон зэрэг нь шаардлагатай мэдээ, тайланг гаргуулах, тайлбар тодруулга авах зэрэгт хүндрэл учирч байсан.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Говьсүмбэр аймгийн хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар 1,441 төрийн албан хаагч бүртгэлтэй байсан бөгөөд үүний 81 хувийг төрийн үйлчилгээний, 15 хувийг төрийн захиргааны, 4 хувийг төрийн улс төрийн болон төрийн тусгай албан хаагч эзэлж байна.

Төрийн албан хаагчдыг насны байдлаар нь авч үзвэл:



Хүснэгтээс харахад: 24 хүртэлх насны албан хаагчид 106 буюу 7 хувь, 25-34 насны албан хаагчид 418 буюу 29 хувь, 35-44 хувь насны албан хаагчид 406 буюу 28 хувь, 45-54 насны албан хаагчид 26 хувь, 55-аас дээш насны албан хаагчид 10 хувийг тус тус эзэлж байна.

Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь салбар зөвлөл нь төрийн байгууллагуудаас ирүүлсэн сул ажлын байрны захиалгад үндэслэн ерөнхий ба тусгай шалгалтыг зохион байгуулж ирсэн байна. 2017-2024 оны 09 сарын байдлаар төрийн албаны мэргэшлийн, ерөнхий ба тусгай шалгалтыг хууль тогтоомжид заасны дагуу 68 удаа зохион байгуулж шалгалтын үр дүнд 206 сул орон тоог нөхжээ.

Төрийн албаны зөвлөлөөс 2023-2024 оны хооронд хууль тогтоомж зөрчин томилогдсон 42 зөрчилтэй томилгоог илрүүлж, холбогдох зөвлөмжийг аймгийн Засаг дарга болон Төрийн албаны салбар зөвлөлийн даргад хүргүүлж үр дүнг тооцсон байна.

Хүснэгтийн товчг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Говьсүмбэр аймгийн төрийн байгууллагуудын бүтэц урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт нийцсэн байдал	8
Хүснэгт 2	Сул орон тооны жагсаалт	10
Хүснэгт 3	Төрийн байгууллагын чиг үүргийг дахин хуваарилах болон мандатын шинжилгээ хийсэн байдал	12
Хүснэгт 4	Нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардлын нэгдсэн судалгаа	13
Хүснэгт 5	2020-2024 оны хооронд тусгай шалгалт зарлаж, сул орон тоонд нэр дэвшүүлсэн байдал	14
Хүснэгт 6	Сонгон шалгаруулалт зарлаагүй болон хууль зөрчиж томилогдсон албан тушаалтны жагсаалт	15
Хүснэгт 7	Төрд учруулсан хохирлын жагсаалт	16
Хүснэгт 8	Улсын төсвийн хөрөнгөөр суралцсан боловч төгсөөгүй албан хаагчдын судалгаа	17
Хүснэгт 9	Төрийн албаны жендерийн харьцаа	18
Хүснэгт 10	Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	19

БҮЛЭГ 1

Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, хууль эрх зүйг хэрэгжүүлэх тогтолцоо бүрэн бүрдээгүй байна.

1.1 Говьсүмбэр аймгийн төрийн байгууллагуудын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц нь урт, дунд хугацааны бодлогын зорилтыг хангахад чиглэгдсэн байна.

1.1.1 Төрийн байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц нь Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн байна.

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т заасны дагуу УИХ-аас баталдаг хуулийн зохицуулалттай байна. МУИХ-ын 2024 оны “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” 13 дугаар тогтоолыг баталжээ.

Засгийн газрын 2021 оны 377 дугаар “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” тогтоолоор аймгийн захиргааны удирдлагын бүтэц, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 26 агентлагийг баталсан байна.

Говьсүмбэр аймгийн төрийн байгууллагуудын бүтэц урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт нийцсэн байдал

Хүснэгт №1

Алсын хараа-2050 урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт хүний нөөцийн талаар дэвшүүлсэн зорилт	Говьсүмбэр аймгийн стратеги	Тухайн чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх байгууллага
1.1.5.Соёл урлагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, хүний нөөцийг хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлсэн байна.	2.Соёл, аялал жуулчлалын салбарыг хүний нөөцөөр хангах, чадавхжуулах	Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын газар Соёлын сайдын 2022 оны А/04-р тушаал, ЗГ-ын 2024 оны 06-р тогтоол
2.1.3 Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан, бүтээлч, чадварлаг багш, хүний нөөцөөр хангана.	2. Боловсрол салбарыг хүний нөөцөөр хангах, чадавхжуулах	Боловсролын газар ЗГ-ын 2024 оны 06-р тогтоол
2.2.4 Эрүүл мэндийн хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулсан байна.	2. Эрүүл мэндийн салбарыг хүний нөөцөөр хангах, чадавхжуулах	Эрүүл мэндийн газар ЗГ-ын 2021 оны 377-р тогтоол
3.5.4.Биеийн тамир, спортын салбарын хүний нөөцийн хөгжил, чадавхжуулалт, дэмжлэгийг нэмэгдүүлнэ.	-	Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын газар - Соёлын сайдын 2022 оны А/04-р тушаал, ЗГ-ын 2024 оны 06-р тогтоол
7.4 Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулан, бүтээн байгуулалтыг дэмжиж, ажиллах нөхцөлийг дээшлүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ.	-	Цагдаагийн газар, ШШГТ, ШШХ ЗГ-ын 2021 оны 377-р тогтоол
8.3.3.Хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, тэдгээрийн тогтвор суурьшилтай ажиллаж, ая тухтай амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулна.	-	МЭГ, ХХААГ

(Эх сурвалж: МУИХ-ын 2020 оны 52р тогтоолын 1-р хавсралт “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, ЗГ-ын 2021 оны 377, 2024 оны 06 дугаар тогтоол, Говьсүмбэр аймгийн стратеги төлөвлөгөө 2021-2024)

Аймгийн ИТХ-ын 2020 оны 04 дүгээр тогтоолоор Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2020 оны 05 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2021 оны А/134 дүгээр захирамжаар Говьсүмбэр аймгийн стратеги төлөвлөгөөг баталсан байна.

Уг стратегийн 2 дахь зорилт **Хүний хөгжлийн бодлого**–“Хүний хөгжлийн бодлогыг дэмжиж, шинэслэх ухаан, инновацид тулгуурлан эрүүл мэнд, боловсрол, соёл, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх” зорилтын хүрээнд Эрүүл мэнд, боловсрол, соёл, аялал жуулчлалын

салбарыг хүний нөөцөөр хангах, чадавхжуулах арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд эдгээр стратеги зорилтууд нь Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт нийцсэн байна.

1.1.2 Батлагдсан үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг төрийн байгууллагууд мөрдөж ажилласан байна.

1.1.3 Төрийн албаны тухай хуульд заасан хүний нөөцийн бодлого болон МУЗНДНТУТХ-д заасан хүний нөөцийн бодлого, хөтөлбөрийг хэрхэн уялдуулж хэрэглэх талаар холбогдох эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу Говьсүмбэр аймгийн стратеги зорилтын хэрэгжилтийг 88.3 хувьтай үнэлж ТЕЗ-д танилцуулсан байна.

Харин Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.5, 21.1.6, 22.1.6-т заасны дагуу аймаг, сум нь хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллахаар хуульчилсан боловч Говьсүмбэр аймгийн хэмжээнд хүний нөөцийн бодлого, хөтөлбөрийг боловсруулж мөрдөөгүй байна.

Энэ нь МУЗНДНТУТХ-д орон нутгийн удирдлага хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх /бодлого, хөтөлбөр/ гэж заасан боловч уг заалт хэт ерөнхий ба Төрийн албаны тухай хуультай хэрхэн уялдах талаар зохицуулалтын дүрэм, журмыг батлаагүйтэй холбоотой байна.

1.1.4 Хяналт шинжилгээ-үнэлгээний хэлтсээс төрийн байгууллагуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр ХШҮ хийж хэвшсэн байна.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д “*Хүний нөөцийн бодлогын баримт бичиг*”-т хяналт шинжилгээ үнэлгээ хийх зохицуулалтгүй байна.

Харин Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр зүйл (захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх)-ийн 9.1.2.3-т заасны дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж хэвшсэн байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар ХЭЗХ-ийн харьяа 5, ХБТХОХ-ийн харьяа 13, ТЗУХ-ийн харьяа 4, СТСХ-ийн харьяа 3, НБХ-ийн харьяа 12, нийт 37 байгууллагад хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн бөгөөд хүний нөөцтэй холбоотой дараах нийтлэг зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилт, үр дүнг тооцож ажилласан байна. Үүнд:

1. Хүний нөөцтэй холбоотой тушаал, шийдвэрийн хуулийн үндэслэлд анхаарах
2. Хуулийн хүрээнд төрийн албаны сул орон тоог зарлан нөхөж, зөрчилтэй томилгоог арилгах
3. Төрийн байгууллагын дотоод удирдлагын ERP системд бүх албан хаагчдыг бүртгэж, байгууллагынхаа дотоод үйл ажиллагаанд ашиглаж, ашиглалтыг сайжруулах
4. Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн төлөвлөгөө, тайлангийн чанарыг сайжруулах, бодит үр дүнтэй төлөвлөлт хийх
5. Төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдлийг журмын дагуу бүрдүүлэх, баяжуулах

1.2 Төрийн байгууллагын хүний нөөцийн хүрэлцээгүй байдал нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлж байна.

1.2.1 Төрийн байгууллагын хүний нөөц хүрэлцээгүй байна.

Төрийн албаны салбар бүрд хүний нөөц хүрэлцээгүй байна. 2024 оны 10 дугаар сарын байдлаар аудитын түүвэрт хамрагдсан 37 байгууллагад 1228 орон тоо батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 1068 албан хаагч ажиллаж, 160 сул орон тоо байна.

Сул орон тоог байгууллагаар нь харуулбал:

Хүснэгт № 2

Байгууллага	Батлагдсан орон тоо				Гүйцэтгэлээр ажилласан орон тоо				Сул орон тоо				Зөрүү
	ТУТ	ТЗ	ТҮ	ТТ	ТУТ	ТЗ	ТҮ	ТТ	ТУТ	ТЗ	ТҮ	ТТ	
Боловсрол		12	628			9	575		0	3	53	0	56
Соёл		10	93			9	82		0	1	11	0	12
Эрүүл мэнд		15	227			7	196		0	8	31	0	39
ЗДТГ	21	69	57	2	21	48	47	2	0	21	10	0	31
ИТХ	3	9	6		4	7	5		-1	2	1	0	2
ХХААГ		11	7			8	6		0	3	1	0	4
ХАА		4	3			2	3		0	2	0	0	2
ОНӨГ		9	3			2	3		0	7	0	0	7
СХДАА		6	1			5	1		0	1	0	0	1
НДХ		13	6			9	5		0	4	1	0	5
БОАЖГ		8	5			7	5		0	1	0	0	1
Нийт	24	166	1036	2	25	113	928	2	-1	53	108	0	160

(Эх сурвалж: Аудитын судалгаа, ажлын баримт, төрийн байгууллагуудын бүтэц орон тоо баталсан тушаал, хүний нөөцийн программын мэдээ)

Хүснэгтээс харахад: Боловсрол, эрүүл мэндийн салбар, ЗДТГ-уудын хүний нөөцийн дутагдал **83.7 хувийг эзэлж** байна.

Эрүүл мэндийн салбар:

Эрүүл мэндийн газарт 2024 оны 10 сарын байдлаар 10 орон тоо дутуу бөгөөд төрийн захиргааны 8, үйлчилгээний 2 албан хаагч дутуу байна. Сул орон тооны зарыг журамд заасан хугацаанд тухай бүр хүргүүлдэг боловч 2015, 2017, 2019, 2020, 2022, 2023 онд бий болсон сул орон тоо одоо болтол нөхөгдөөгүй байна.

Нэгдсэн эмнэлэг, сумдын ЭМТ-үүдэд нийт 29 орон тоо дутуу бөгөөд өдрийн эмчилгээний эмч, статистик эмч, дүрс оношилгоо, багийн эмч, дуудлага хүлээн авагч, уламжлалтын эмч, ахмад, дотрын эмч, зүрх судас, дотрын эмч, чих хамар хоолойн эмч, асрагч, сувилагч гэсэн орон тоо дутуу байна.

Дутуу орон тоог хавсран гүйцэтгүүлэх байдлаар тусламж үйлчилгээг үзүүлж байгаа ч энэ нь үйлчилгээний чанар, хүртээмжтэй байдалд сөрөг нөлөө үзүүлж иргэдийн бухимдлыг төрүүлж байна.

Боловсролын салбар:

Боловсролын газарт 2024 оны 10 сарын байдлаар 4 орон тоо дутуу бөгөөд төрийн захиргааны 3, үйлчилгээний 1 албан хаагч дутуу байна. Боловсролын мэргэжилтний орон тоо дутуу байгаа шалтгаан нь цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, нийгмийн баталгаа нь хангагдахгүй байгаагаар холбоотой байна.

Орон нутгийн сургууль, цэцэрлэгүүдэд 52 орон тоо сул байна. Нийтлэг дутагдалтай байгаа орон тоог авч үзвэл математикийн багш-5, гадаад хэлний багш-8, бага ангийн багш-7, дуу хөгжмийн багш-5, СӨБ-ийн сэтгэл зүйч-4, нягтлан бодогч-4 байна.

Аймаг, сумын ЗДТГ:

Аймгийн ЗДТГ-т төрийн захиргааны-7, үйлчилгээний 2, Сүмбэр сумын ЗДТГ-т ТЗ-ны 4, ТҮ-ний 3, Шивээговь сумын ЗДТГ-т ТЗ-ны 4, ТҮ-ний 5, Баянтал сумын ЗДТГ-т ТЗ-ны 6, нийт 33 орон тоо сул байна.

Энэ нь ЗДТГ-ын батлагдсан орон тооны 20 хувийг эзэлж байна. Сумдын ЗДТГ-т Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Байгаль орчны мэргэжилтэн, Бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн, багийн нийгмийн ажилтан гэх мэт нарийн мэргэжил шаардсан албан тушаалын орон тоо нийтлэг байдлаар сул, нөхөгдөхгүй байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын 2022, 2023 оны хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаанд дээрх ажлын байрууд нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй мэргэжлийн жагсаалтад

багтсан байна. Хөдөлмөрийн зах зээл дээрх мэргэжлийн боловсон хүчний эрэлт ихтэй тул цалин хөлс, нийгмийн баталгааг хангах байгууллагад ажиллах сонирхол илүү байна.

Төрийн байгууллагын хүний нөөцийн тогтолцоо уян хатан бус, зөвхөн хууль тогтоомжийн хүрээнд нөөц бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулдаг тул төрийн албан хаагчдын хүрэлцээг нэмэгдүүлэх боломж, тогтолцоо бүрдээгүй байна.

Аудитаар 242 төрийн албан хаагчаас авсан санал асуулгаар “Та ойрын хугацаанд өөр ажил, албан тушаалд шилжих бодолтой байна уу?” гэж асуухад 25.6 хувь нь Тийм гэж хариулжээ.

1.2.2 Төрийн байгууллагууд хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээ, хүний нөөцийн талаарх мэдээллийг бүрэн мэдээлэхгүй байна.

Нийтийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан 68 төрлийн мэдээллийг байгууллага бүр ил тод нээлттэй байршуулах үүрэгтэй байна.

Аудитаар 21 байгууллагыг түүвэрлэн дээрх шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд төрийн байгууллагууд үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг нээлттэй мэдээлж хэвшсэн бол хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээ, хүний нөөцийн талаарх мэдээллийг бүрэн мэдээлэхгүй байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах, төрийн үйлчилгээг цахимжуулах арга хэмжээ”-г төлөвлөж, 2023 онд 15 арга хэмжээнд 111.5 сая төгрөгийг төлөвлөж зарцуулсан байна.

Уг арга хэмжээний хүрээнд “Монголын үнэн сонин”-ны 9 дугаарт 54 цаг үеийн мэдээ, Гайхамшигт Монгол наадахай студитэй хамтран 38 видео контент бэлтгэж 12.1 мянган хандалт, Говьсүмбэр телевизтэй хамтран 5 шууд дамжуулалт, 22 видео контентыг давхардсан тоогоор 32.3 мянган хүнд хүргэсэн байна. Мөн E-mongolia цахим системээр төрийн байгууллагын үйлчилгээг үзүүлж, Говьсүмбэр аймгийн 15 байгууллагын 61 төрлийн үйлчилгээг цахимд шилжүүлж, ERP системд 56 байгууллагын 503 албан хаагчийг холбож мэдээлэл солилцох цахим системийг нэвтрүүлжээ.

Тус арга хэмжээний төсвийн зарцуулалтыг 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад 97.7 сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. “Аймгийн 30 жилийн ой болон Боржигин өв соёлыг сурталчлах ном, сэтгүүл хэвлүүлэх” 52.7 сая төгрөгийн 3700 ш зургийн цомгийг шууд зардлаар бүртгэсэн байх тул авлага үүсгэн бүртгүүлсэн.
2. “Монгол наадахай” хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй 45.0 төрийн болон гэрээ байгуулахдаа харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт зохион байгуулахгүйгээр шууд гэрээ байгуулсан тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Цаашид аймгийн төрийн байгууллагуудын ил тод байдлыг сайжруулах, Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээний зарцуулалтыг худалдан авах ажиллагааны хууль тогтоомжид нийцүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

1.2.3 Төрийн албаны хүний нөөц дутагдалтай, сул орон тоо нөхөгдөхгүй байгаа шалтгаанаар ажил үүргийг хавсран гүйцэтгүүлэх замаар нөөцийн хуваарилалтыг хийж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоолоор Сумын засаг даргын тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоосон байна. Уг тогтоол нь хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, үйлчлэх өрх, аж ахуй нэгжийн тоо, байгууллагын тоог харгалзсан бөгөөд хамгийн сүүлд Засгийн газрын 2018 оны 267-р тогтоолоор өөрчлөлт оржээ.

- Засгийн газрын болон аймгийн ЗДТГ-ын бүтцэд өөрчлөлт орж түүнийг дагасан шинэ бүтцийн нэгжүүд бий болсон боловч сумын ЗДТГ-ын бүтцэд өөрчлөлт оруулаагүй байна. Үүнээс шалтгаалан анхан шатанд ажиллаж буй төрийн албан хаагчдын гүйцэтгэх чиг үүрэг нэмэгджээ. Тухайлбал: суманд нийгмийн бодлогын 1 мэргэжилтэн эрүүл мэнд, боловсрол, соёл, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, хүүхэд хамгаалалтай холбоотой 6 чиг үүргийг хариуцан ажиллаж байна.

- Баянтал суманд нийгмийн бодлогын мэргэжилтэн худалдан авах ажиллагааг давхар хариуцаж байгаа бөгөөд багш мэргэжилтэй албан хаагчид санхүү, эдийн засаг, инженерийн албан тушаалын тодорхойлолттой албан тушаалыг давхар хариуцуулсан.

Суманд хүний нөөцийн дутагдалтай байдлаас шалтгаалж 1 албан хаагчид үндсэн чиг үүрэгт нь хамааралгүй хэд хэдэн ажил, албан тушаалыг хавсран гүйцэтгүүлэх байдал нийтлэг байна. Энэ нь орон тоо дутуугаас төрийн байгууллагууд хүний нөөцийн хуваарилалтыг үр дүнтэй хийх нөхцөл бүрдэхгүй байгаатай холбоотой байна.

1.3 Томилох эрх бүхий албан тушаалтнууд 4 албан тушаалд сул орон тооны зарыг тухай бүр хүргүүлээгүй, хуульд заасан шалгуурыг хангаагүй 4 хууль бус томилгоо хийсэн байна.

1.3.1 Эрх бүхий байгууллагуудаас төрийн байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийж давхардал, хийдлийг арилгах арга хэмжээ авсан байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.11¹, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-аар төрийн байгууллагын чиг үүргийн хуваарилалт, мандатын шинжилгээ хийх, давхардал, хийдлийг арилгах хууль эрх зүйн зохицуулалттай байна.

Төрийн байгууллагын чиг үүргийг дахин хуваарилах болон мандатын шинжилгээ хийсэн байдал Хүснэгт № 3

№	Шалгуур	Аймгийн хэмжээнд хийсэн эсэх	АЗДТГ-ын хэмжээнд хийсэн эсэх	Тайлбар
1	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ын 6 ² дугаар зүйл		Тийм	Аймгийн ЗДТГ-ын даргын 2022 оны А/07-р тушаалаар бүтэц орон тооны өөрчлөлттэй холбоотойгоор байгууллагын чиг үүргийн болон ажлын байрны шинжилгээ хийсэн байна.
2	Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам	Тийм		Мандатын шинжилгээг Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд хийж ерөнхий-1, үндсэн-3, дэд-35, хамтран хэрэгжүүлэх 77 чиг үүргийг тус тус тодорхойлсон байна.

(Эх сурвалж: Говьсүмбэр аймгийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөө)

1.3.2 Төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгаагаар хангах үйл явц төрийн байгууллага бүрд харилцан адилгүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3³, 57, 59, 60, 61 дүгээр зүйлд заасны дагуу төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хуулиар тогтоож өгсөн байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан арга хэмжээнүүдийн 2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсвийн задаргааг шинэчлэн батлах тухай А/369 дүгээр захирамжийн 17 дугаар хавсралтаар “Төрийн албан хаагчдын мэдлэг чадварын дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээний төлөвлөгөө”-нд 67.5 сая төгрөгийг төсөвлөсөн боловч *гүйцэтгэлээр зөвхөн төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх*

¹ 14.2.11.төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах;

² 6. Чиг үүргийн шинжилгээ хийх, дахин хуваарилах санал боловсруулах үүрэг бүхий техникийн ажлын хэсгийг (цаашид “ажлын хэсэг” гэх) холбогдох төрийн захиргааны төв байгууллага, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд байгуулна.

³ 55.3.Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

арга хэмжээнд нийт төсвийг зарцуулжээ. Засаг даргын баталсан дээрх төлөвлөгөөнд нийгмийн баталгааг хангах арга хэмжээг **тухайн байгууллагын төсвөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн** байна.

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар Төрийн албан хаагчдын орон нутагт ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор ТЗ, ТҮ, УТ-ийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох журмыг баталсан.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/14 дүгээр захирамжаар орон нутгийн нэмэгдлийг ТЗ-ны албан хаагчид 80 хувь, А/15 дугаар захирамжаар ТҮ-ний албан хаагчид 20 хувь олгохоор шийдвэрлэсэн бөгөөд 2023 оны А/234, А/236 дугаар захирамжаар өөрчлөлт, шинэчлэлт оруулж улсын болон орон нутгийн төсвийн ТЗ-ны албан хаагчдад 20 хувь, ТҮ-ний албан хаагчдад олгож байсан нэмэгдлийг зогсоожээ. Орон нутгийн нэмэгдэлд 490.1 сая төгрөгийг зарцуулсан нь төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлсэн байна.

Мөн төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор орон сууцны түрээсийн дэмжлэг, орон нутагт ажиллах хугацаанд орон байраар хангах асуудлыг АЗДҮАХ хөтөлбөрийн Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд болон байгууллага өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан шийдвэрлэж ирсэн байна. 2024 оны байдлаар Эрүүл мэндийн салбарын 20, боловсролын салбарын 9, мал эмнэлгийн 1, соёлын салбарын 1, нийт 31 албан хаагчид түрээсийн дэмжлэг үзүүлэх болон орон байраар хангасан байна.

Төрийн албаны салбар зөвлөлөөс жил бүр төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан хөрөнгийн судалгааг орон нутгийн хэмжээнд байгууллага бүрээр нь нэгтгэн төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн байна.

Нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардлын нэгдсэн судалгаа:

Хүснэгт № 4

/сая төгрөг/

Хуулийн заалт	2020		2021		2022		2023		Нийт	
	Албан хаагчийн тоо	Мөнгөн дүн	Албан хаагчийн тоо	Мөнгөн дүн	Албан хаагчийн тоо	Мөнгөн дүн	Албан хаагчийн тоо	Мөнгөн дүн	Албан хаагчийн тоо	Мөнгөн дүн
59.1.1.	561	62.3	568	90.0	735	103.4	559	222.1	2,423	477.8
59.1.2.	46	8.4	124	39.4	59	18.6	128	7.5	357	73.9
59.1.3.	36	1.4	26	1.9	2	0.7	1	0.1	65	4.2
59.1.4.	0	-	0		1	4.6	3	0.6	4	5.2
59.1.5.	0	-	0		0		13	1.9	13	1.9
59.1.6.	3	0.5	3	0.3	0		0		6	0.8
59.1.7.	0	-	0	-	0		0		-	-
59.1.8.	302	81.9	163	66.3	62	40.1	970	2,323.4	1,497	2,511.7
60.1.	15	319.5	9	143.9	54	614.6	22	574.3	100	1,652.4
60.2.	0	-	0	-	1	49.9	0		1	49.9
61.1.5.	9	22.6	1	3.5	19	7.6	38	31.8	67	65.5
61.1.7.	19	83.1	17	38.9	8	34.5	19	15.1	63	171.6
61.1.9.	5	16.8	9	9.9	7	7.0	13	23.0	34	56.7
Дүн	996	596.6	920	394.1	948	881.1	1,766	3,199.9	4,630	5,071.7

(Эх сурвалж: ТАСЗ-ийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардлын нэгдсэн судалгаа)

Хүснэгтээс харахад: 2020-2024 онд давхардсан тоогоор 2,423 төрийн албан хаагчид дотоод албан томилолтын зардалд 477.8 сая, албан хэрэгцээнд хувийн унаа ашигласан 357 албан хаагчид 73.9 сая, ачаа тээшний зардал 65 албан хаагчид 4.2 сая, ХЧТА 4 албан хаагчид 5.2 сая, албан үүргээ гүйцэтгэх явцдаа гэмтэл авсан 13 албан хаагчид 1.9 сая, ээлжийн амралтаар нутаг явсан, дотоодын сувилалд сувилуулсан 6 албан хаагчийн ирэх буцах унааны зардалд 0.8 сая, бусад нөхөх төлбөр 1,497 албан хаагчид 2,511.7 сая /Бусад хууль тогтоомж, ЗГ-ын тогтоолоор олгох нөхөх төлбөр/, өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн 100 албан хаагчид 1,652.4 сая, албан үүргээ гүйцэтгэх явцдаа амь насаа алдсан албан хаагчийн ар гэрт 49.9 сая, орон байраар хангахад түрээсийн дэмжлэг 67 албан хаагчид 65.5 сая, төрийн хөрөнгөөр 6 хүртэлх сарын хугацаагаар

суралцаж байгаа албан хаагчийн албан тушаалын цалин 171.6 сая, ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй 34 албан хаагчид 56.7 сая төгрөгийн урамшууллыг тус тус олгосон байна.

Нийгмийн баталгааг хангах арга хэмжээг байгууллагын батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжүүлж, тайлагнаж ирсэн бөгөөд төрийн байгууллагуудын төсөв харилцан адилгүй батлагддаг нь уг хөтөлбөр төрийн албан хаагч бүрийн нийгмийн баталгааг хангах, ижил тэгш хэрэгжихгүй байх шалтгаан болж байна.

Аудитаар 242 Төрийн албан хаагчаас авсан санал асуулгаар “Таны ажиллах нөхцөл нийгмийн баталгаа хангагдаж байна уу? гэсэн асуултад 192 буюу 79.3 хувь нь тийм гэж хариулжээ.

1.3.3 Томилох эрх бүхий албан тушаалтнууд 4 албан тушаалд сул орон тооны зарыг тухай бүр хүргүүлээгүй, хуульд заасан шалгуурыг хангаагүй 4 хууль бус томилгоо хийсэн байна.

Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1⁴-т заасны дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонд сонгон шалгаруулж томилох, 27 дугаар зүйлийн 27.2⁵-т томилох эрх бүхий байгууллага сул орон тооны мэдээллийг 7 хоногийн дотор, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэх хуулийн зохицуулалттай байна.

Төрийн байгууллагууд сул орон тооны мэдээллийг Төрийн албаны тухай хуульд заасан хугацаанд нь мэдээлдэггүйгээс томилох эрх бүхий албан тушаалтнууд сонгон шалгаруулалтгүй түр томилгоо хийх зөрчил арилахгүй байна.

2020-2024 оны хооронд тусгай шалгалт зарлаж, сул орон тоонд нэр дэвшүүлсэн байдал
Хүснэгт №5

№	Тусгай шалгалт	Сонгон шалгаруулалт зарласан		Үүнээс		Бүртгүүлэх хүсэлт ирүүлсэн иргэний тоо	Бүртгүүлсэн хүний тоо	Шалгалтад оролцсон хүний тоо			Сул орон тоог нөхсөн эсэх
		Байгууллагын тоо /Давхардсан тоогоор/	Ажлын байрны тоо	Удирдах	Гүйцэтгэх			Нийт	тэнцсэн	тэнцээгүй	
1	ТЗ-ны удирдах албан тушаал	35	54	54	-	38	26	25	24	1	21
2	Дэс, туслах түшмэлийн гүйцэтгэх	96	339	-	339	149	132	116	116	-	119
3	ТҮ-ний удирдах албан тушаал	11	11	11	-	8	7	5	4	1	4
Нийт		142	404	65	339	195	165	146	144	2	144

(Эх сурвалж: ТАСЗ-ийн 2020-2024 оны 09 сарын 30 хүртэлх сонгон шалгаруулалтын баримт, үйл ажиллагааны тайлан, тогтоол, ирсэн явсан бичиг)

2020-2024 оны хооронд давхардсан тоогоор 142 байгууллагаас 404 сул орон тооны захиалгыг ТАСЗ-д хүргүүлсэн бөгөөд дээрх сул орон тоонд 165 иргэн бүртгүүлж, нийт сул орон тооны 35.6 хувь буюу 144-ийг тусгай шалгалтын үр дүнгээр бүрдүүлсэн байна. Сонгон шалгаруулалтад бүртгүүлж оролцсон болон тэнцсэн хүмүүсийн харьцааг авч үзвэл 165/144 буюу тухайн ажлын байран дээр ямар нэг өрсөлдөгчгүй томилогджээ. Энэ орон нутагт хүний нөөц дутагдалтай байгааг харуулж байгаа бөгөөд өрсөлдөх чадвар сул байна.

⁴ 25.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалд энэ хуулиар тогтоосон шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг сонгон шалгаруулж томилно.

⁵ 27.2.Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.

Сул орон тоог зарласан эсэх, хууль тогтоомжийн дагуу нөхөн томилсон байдлыг түүвэрлэн шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сонгон шалгаруулалт зарлаагүй болон хууль зөрчиж томилогдсон албан тушаалтны жагсаалт

Хүснэгт №6

№	Ангилал, зэрэглэл	Томилох эрх бүхий этгээд	Албан тушаалын нэр	Захиалга ирүүлсэн эсэх	Зөрчил	Тайлбар
1	ТҮ-ний төсвийн шууд захирагч	Боловсролын газрын дарга	Насан туршийн боловсролын төвийн дарга	Үгүй	2023.07.20-ноос хойш сул орон тооны захиалгыг ирүүлээгүй.	ТӨЗ-ийн 2023 оны 25-р тогтоол 2.1.3.2
2	ТҮ-ний төсвийн шууд захирагч	Аймгийн Засаг дарга	Боржигин өв музейн захирал	Үгүй	Түр орлон гүйцэтгэгч томилон ажиллуулсан.	ТӨЗ-ийн 2023 оны 25-р тогтоол 2.1.3.2, 5.1.10
3	ТҮ-ний төсвийн шууд захирагч	Аймгийн Засаг дарга	Нийтийн номын сангийн захирал	Үгүй	Түр орлон гүйцэтгэгч томилон ажиллуулсан.	ТӨЗ-ийн 2023 оны 25-р тогтоол 2.1.3.2, 5.1.10
4	ТЗ-ны ахлах түшмэлийн удирдах	Сумын Засаг дарга	Баянтал сумын ЗДТГ	Үгүй	Түр орлон гүйцэтгэгч томилон ажиллуулсан.	ТАТХ-н 25.1
5	ТЗ-ны дэс түшмэлийн гүйцэтгэх	ХХААГ-ын дарга	Малын үржил, селекци, эрчимжүүлэлт, малын удам зүйн үнэлгээ, итгэмжлэл, усан хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Тийм	Тусгай шаардлага хангаагүй албан тушаалтыг түр томилсон.	ТАТХ-н 25.1, ТӨЗ-ийн 2023 оны 25-р тогтоол 5.1.5

(Эх сурвалж: Тухайн албан хаагчдыг томилсон шийдвэр)

Хүснэгтээс харахад: Төрийн үйлчилгээний 2 төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулалтгүй, төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалд сонгон шалгаруулалтгүй, албан тушаалын тусгай шаардлагыг хангаагүй албан тушаалтныг томилсон байна. Мөн Насан туршийн боловсролын төвийн даргын сул орон тоог 2023 оноос хойш зарлаагүй, мэргэжилтнээр даргын үүргийг түр орлон гүйцэтгүүлэхээр томилсон байна.

Эдгээр нь Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4⁶ 25 дугаар зүйлийн 25.1⁷, 27 дугаар зүйлийн 27.1.2⁸, 43 дугаар зүйлийн 43.6⁹ Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам, загвар батлах тухай” журмын 2 дугаар зүйлийн 2.1.3.2¹⁰, 5 дугаар зүйлийн 5.1.5¹¹, 5.1.10¹²-т заасныг зөрчсөн байна. Хууль тогтоомж зөрчин хууль бус томилгоо хийж байгаа нь төрийн албаны зарчимд нийцэхгүй бөгөөд Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1¹³-т заасны дагуу томилсон эрх бүхий этгээд нь төрд учирсан хохирлыг барагдуулах үр дагавартай байна.

⁶ 7.1.4.Монгол Улсын иргэн төрийн алба хаах адил тэгш боломжоор хангагдах;

⁷ 25.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалд энэ хуулиар тогтоосон шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг сонгон шалгаруулж томилно.

⁸ 27.1.2.төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчаас болон холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчаас;

⁹ 43.6.Энэ хуульд заасан журмыг зөрчиж, төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхийг хориглоно.

¹⁰ 2.1.3.2.төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалт.

¹¹ 5.1.5.хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн үүргээ биелүүлсэн байх;

¹² 5.1.10.зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

¹³ 50.1.Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ.

Иймд Төрийн албаны салбар зөвлөлд Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх, томилох эрх бүхий албан тушаалтнуудыг удирдлага арга зүйгээр хангах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Албан тушаалын сул орон тоог зарлаагүй, түүнд шаардлага хангаагүй албан тушаалтан томилсон нь тухайн ажлын байрыг уг албан тушаалтанд зориулан хадгалсан байх эрсдэлийг үүсгэж байх тул томилох эрх бүхий этгээдүүд нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба хаах адил тэгш боломжоор хангаж ажиллах нь зүйтэй.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.2¹⁴-т заасны дагуу албан тушаалын тодорхойлолтод мэргэжлийн шаардлагыг тусгаж байна. АТТ-д мэргэжлийн шалгуурыг тавихдаа Боловсролын сайдын тушаалаар баталсан мэргэжлийн индексийг ашиглаж байна.

Албан тушаалын тодорхойлолтод мэргэжлийн индексийг /ерөнхий, төрөлжсөн, нарийвчилсан/ хэрхэн ашиглах талаар нэгдсэн ойлголт, зохицуулалт байхгүйгээс нарийвчилсан байдлаар тусгасан тохиолдолд зөвхөн тухайн индексэд таарах мэргэжилтэй хүнийг томилох шаардлага тулгарч сул орон тоо нөхөгдөхгүй байх тохиолдол түгээмэл байна. Нөгөөтгээгүүр ерөнхий болон төрөлжсөн индекс тавьсан бол тухайн албан тушаалын сул орон тоог нөхөх боломж илүү нэмэгдэх боломжтой байна.

Мөн мэргэжлийн индексийг шинэчлэн батлахдаа өмнө батлагдсан индексийг хүчингүй болгодог бөгөөд үүнээс шалтгаалж одоо мөрдөгдөж буй АТТ-д заасан индекстэй хэрхэн нийцэх нь зохицуулалтгүй байна. Дээрх шалтгаанууд нь төрийн албаны нөөц бүрдүүлэх үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна.

Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-аар төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх харилцааг зохицуулж байна.

Төрийн албаны салбар зөвлөл нь төрийн албан хаагчийг нөөцөд бүртгэх болон нөөцөөс тусгай шалгалтад бүртгэхдээ нотлох баримтад үндэслэх бус зөвхөн ажлаас чөлөөлсөн тушаалын үндэслэлийг шалгаж бүртгэдэг байна. Цаашид нөөцийн бүртгэлийг орон нутагт цахимжуулах, нэгдсэн мэдээллийн сантай болгох, нотлох баримтад үндэслэн бүртгэх зэргээр үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байх тул журамд өөрчлөлт оруулах саналыг УАГ-т уламжлах санал хүргүүлэхээр шийдвэрлэв.

Үндэсний аудитын газарт уламжлах санал: "Төрийн албаны хүний нөөцийн бүртгэлийг орон нутагт цахимжуулах, нэгдсэн мэдээллийн сантай болгох, нотлох баримтад үндэслэн бүртгэх зэргээр үр дүнтэй хэрэгжүүлэх" зөвлөмжийг Төрийн албаны төв зөвлөлд хүргүүлэх

1.3.4 Төрд учруулсан хохирлын талаарх мэдээлэл хангалтгүй, хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоо бүрдээгүй байна.

2024 оны 10 дугаар сарын байдлаар шүүхийн шийтгэх тогтоолоор 289.8 сая төгрөгийн төрд учруулсан хохирлыг буцаан төлүүлэх шийдвэр гарсан байна. Үүнээс Төрийн албаны зөвлөл нь 2 хэрэгт нэхэмжлэгчээр оролцож шүүхээс 32.4 сая төгрөгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр шийдвэрлэжээ.

Төрд учруулсан хохирлын жагсаалт

Хүснэгт №7

Шийтгэх тогтоол огноо	Давж заалдах	Шийтгэх тогтоолын дугаар	Төрд учруулсан хохирлын мөнгөн дүн
2024.01.09		2024/ШЦТ/07	53.1
2024.01.17	2024.05.07 2024/ДШМ/10	2024/ШЦТ/12	51.5
2023.08.18		2023/ШЦТ/67	17.5
2023.08.14		2023/ШЦТ/64	58.1

¹⁴ .5.2.төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах мэргэжил ба мэргэшлийн[1] шаардлагыг тухайн албан тушаалын чиг үүрэгт нийцүүлэн, албан тушаалын тодорхойлолтод тусгана.

2023.08.22		2023/ШЦТ/69	39.3
2023.08.21		2023/ШЦТ/68	38.0
2024.08.09		134/ШШ2024/00176	15.5
2024.03.15	216/МА2024/00005	134/ШШ2024/00082	16.9
Нийт			289.8

(Эх сурвалж: Шүүхийн шийтгэх тогтоол, ШШГТ-ын албан бичиг)

Төрийн албаны тухай хуулиар Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төлөлтөд хяналт тавих чиг үүрэгтэй байна. Орон нутагт шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийн талаар иж бүрэн мэдээлэл, судалгаа байхгүй, хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо бүрдээгүй байна. Үүнээс шалтгаалж төрд хохирол учруулсан этгээд хохирлоо барагдуулаагүй, зөрчлөө арилгаагүй боловч өөр орон нутаг бусад төрийн байгууллагад дахин ажилд орох эрсдэлтэй байна.

Үндэсний аудитын газарт уламжлах санал: "Төрд учруулсан хохирлын талаарх цахим мэдээллийн сан үүсгэж хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх" зөвлөмжийг Төрийн албаны төв зөвлөлд хүргүүлэх

1.3.5 Хүний нөөцийн удирдлага мэдээллийн системээр дамжуулан хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж чадаагүй байна.

Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5¹⁵-д заасны дагуу Төрийн албаны зөвлөл хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системийг ашиглан нэгдсэн тоо бүртгэлийн мэдээллийн санг бүрдүүлж байна.

Уг журмын 4 дүгээр зүйлийн 4.1.1.5¹⁶-д заасны дагуу Төрийн албаны салбар зөвлөл нь төрийн байгууллагын хүний нөөцийн мэдээллийн системд оруулсан мэдээллийн үнэн зөв байдалд хяналт хэрэгжүүлэх чиг үүрэгтэй боловч уг чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Төрийн албаны салбар зөвлөл нь байгууллагуудын оруулсан хүний нөөцийн мэдээлэлд хандаж татаж авах, боловсруулалт хийх эрх үүсээгүй, төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй байгууллага бүрээр нэгтгэн дүн шинжилгээ хийх боломжгүй байгаа нь мэдээллийн системд оруулсан мэдээллийг үр дүнтэй ашиглах нөхцөл бүрдээгүй байгааг харуулж байна.

Үндэсний аудитын газарт уламжлах санал: "Төрийн байгууллагын хүний нөөцийн цахим системээс мэдээллийг татаж авах, орон нутгийн хэмжээнд нэгтгэх, бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг цахим системээр гаргах эрхийг төрийн албаны салбар зөвлөлд өгөх"

БҮЛЭГ 2

Төрийн байгууллагын хүний нөөцийн тогтолцоо сайн засаглалыг дэмжихэд чиглэгдсэн боловч зорилтдоо хүрч чадаагүй байна.

2.1. Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх үр дүнтэй тогтолцоо бүрдээгүй байна.

2.1.1. Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх сургалтад хамруулж байгаа боловч үр дүнг нь тооцохгүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 24, 29 дүгээр зүйлд заасан сургалтын үйл ажиллагааг Удирдлагын академи хариуцан төрийн албан хаагчдыг доорх 4 төрлийн сургалтад хамруулж байна. Говьсүмбэр аймгийн хэмжээнд 2020-2024 оны хооронд 177 албан хаагч суралцсан бөгөөд үүний 135 буюу 76.2 хувь нь төгсжээ.

¹⁵ Тоо бүртгэлийн мэдээллийн санг бүрдүүлэхдээ Төрийн албаны "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо (цаашид "ХНУМТ" гэх) цахим системийг ашиглана.

¹⁶ 4.1.1.5. Төрийн албаны салбар зөвлөл болон салбар зөвлөлгүй төрийн байгууллага ХНУМТ цахим системд төрийн албан хаагчийн мэдээллийг үнэн зөв, тухай бүр оруулж байгаа эсэхэд хяналт тавих;

Улсын төсвийн хөрөнгөөр суралцсан боловч төгсөөгүй албан хаагчдын судалгаа

Хүснэгт №8

№	Сургалт	Төлбөр	Суралцаж буй албан хаагчдын тоо /жилээр/					/сая.төг/	
			2020	2021	2022	2023	2024	Тоо	Дүн
1	Төрийн албан анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх	1.815	1	4	3	8	4	20	36.3
2	Мэргэшүүлэх дунд хугацааны давтан	1.485		1	2	4	5	12	17.8
3	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх	1.485	1		1			2	3.0
4	Эрхэлсэн түшмэл мэргэшүүлэх	1.620				1	1	2	3.2
Нийт			2	5	6	13	10	36	60.3

(Эх сурвалж: Удирдлагын академийн 2024.10.25-ны 08/292 тоот албан бичиг)

Хүснэгтээс харахад: Улсын төсвийн хөрөнгөөр 2020-2024 оны 3 дугаар улирлын байдлаар багц цагийг хугацаандаа судалж төгсөөгүй 36 албан хаагч байгаа бөгөөд дээрх зардалд 60.3 сая төгрөгийг төсвөөс төлсөн байна.

Төрийн албаны салбар зөвлөлөөс удирдлагын академид суралцах албан хаагчдыг байгууллагаас нь ирүүлсэн хүсэлтийг үндэслэн суралцуулж байгаа боловч тухайн албан хаагч хэрхэн суралцсан үр дүнг нь тооцохгүй байгаа нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлийг бий болгож байна.

Улсын төсвийн хөрөнгөөр суралцсан албан хаагчидтай эрх үүргийг тодорхойлсон гэрээ байгуулах, үүргээ биелүүлээгүй нөхцөлд төлбөрийг буцаан төлүүлэх зэргээр хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан арга хэмжээнүүдийн 2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсвийн задаргааг шинэчлэн батлах тухай А/369 дүгээр захирамжийн 17 дугаар хавсралтаар “Төрийн албан хаагчдын мэдлэг чадварын дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээний төлөвлөгөө”-нд 12 арга хэмжээг 67.5 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 52.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Сургалтад давхардсан тоогоор нийт 2,544 албан хаагч оролцжээ.

Та “Мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж байсан уу?” гэсэн асуултад 16 байгууллагын 232 албан хаагч оролцсон бөгөөд 130 буюу 56 хувь нь тийм гэж хариулсан байна.

Үндэсний аудитын газарт уламжлах санал: “Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад улсын төсвөөс суралцсан боловч эрх, үүргээ биелүүлээгүй албан хаагчдын сургалтын төлбөрийг буцаан төлүүлэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох”

2.1.2. Газар зүйн байршлаас үл хамааран албан хаагчийг сэлгэн шилжүүлэн ажиллуулсан байна.

Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйл¹⁷, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, төрийн албан зөвлөлийн даргын 2019 оны 34/31 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-д заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах хуулийн зохицуулалттай байна.

Говьсүмбэр аймгийн хэмжээнд 2023 оноос өмнө хэдэн төрийн жинхэнэ албан хаагч шилжин буюу сэлгэн ажилласан талаарх статистик мэдээ, тайлан олдоогүй бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар Төрийн албаны тухай хуулийн 44.1, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1-т заасан үндэслэлээр 1 албан хаагчийг өөр орон нутагт шилжүүлж, өөр орон нутгаас болон аймаг дотроо нийт 14 албан хаагч 11 байгууллагад шилжин ажилласан байна.

2.1.3. Орон нутагт төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай төрийн албан хаагчийн хүний нөөцийг бэлтгэх зохицуулалт байхгүй байна.

¹⁷ Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах

Засгийн газрын 2022 оны 499 дүгээр тогтоолоор орон нутагт төрийн цахим үйлчилгээний хэлтсийг байгуулсан бөгөөд аймгийн ЗДТГ-ын бүтцэд харьяалагдаж байсан цахим үйлчилгээний операторыг уг хэлтэст шилжүүлсэн байна. Орон нутагт төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх чиг үүрэг бүхий бүтэц зохион байгуулалтын нэгж байхгүй байна.

2.1.4 Говьсүмбэр аймагт төрийн албаны жендерийн тэнцвэртэй байдал 68 хувьтай байна.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2¹⁸, 10.1.4¹⁹-т заасны дагуу төрийн албан дахь жендерийн эрх тэгш байдлын баталгааг хуулиар зохицуулж байна.

Төрийн албаны жендерийн харьцаа								
Хүснэгт №9								/тоо/
Он	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Эрэгтэй	454	432	413	409	341	325	357	401
Эмэгтэй	788	838	858	820	893	920	1040	1040
Нийт	1242	1270	1271	1229	1234	1245	1397	1441
Эмэгтэйчүүдийн эзлэх хувь	63%	66%	68%	67%	72%	74%	74%	72%

(Эх сурвалж: Статистикийн мэдээлэл 1212.mn)

Хүснэгтээс харахад: Төрийн албанд ажиллаж буй эмэгтэй албан хаагчид 72 хувийг эзэлж байна. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 6.5.6-т заасны дагуу сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж буй 181 орон тоог хасаж тооцвол энэ харьцаа **68** хувь байна. Мөн удирдах бүрэлдэхүүний хувьд авч үзвэл нийт 83 удирдах албан тушаалтны 41 нь эрэгтэй, 42 нь эмэгтэй буюу аль нэг хүйс давамгайлаагүй байна.

АЗДҮАХ-ийн 2.5.5.5-т жендерийн эрх тэгш байдлыг хангах зорилтот бүлгийн иргэдийг дэмжих арга хэмжээний төлөвлөгөөг Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/41 дүгээр захирамжаар батлан 6 арга хэмжээг төлөвлөн бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. Тус үйл ажиллагаанд 6.2 сая төгрөгийг зарцуулан, 885 иргэнийг хамруулжээ. Арга хэмжээний хүрээнд зорилтот бүлгийн иргэдийн спортын уралдаан тэмцээн, сургалт зохион байгуулах, нөлөөллийн ажилд зарцуулсан бөгөөд төрийн албан жендерийн эрх тэгш байдлыг хангахад хөрөнгө зарцуулаагүй байна.

2.2. Иргэд төрийн үйлчилгээг орон зайнаас үл хамааран цахимаар авах нөхцөл боломж бүрдсэн байна.

2.2.1. Цахим технологи ашиглан иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж байна.

Говьсүмбэр аймгийн хэмжээнд “ХУРДАН” төрийн үйлчилгээний нэгдсэн 3 цэг, Сүмбэр, Шивээговь, Баянтал сумын ЗДТГ-т байрлах оператор эрхтэй үйлчилгээний ажилтнууд нийт 6 цэгээр төрийн үйлчилгээг үзүүлж байна.

Хурдан цэгээс 43 төрийн байгууллагын 478 үйлчилгээг шууд авах боломжоор хангасан бөгөөд 2023 оноос хойш Говьсүмбэр аймгийн 13,115 иргэнд төрийн үйлчилгээг цахимаар хүргэжээ.

Цахим технологи ашиглан төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байгаа боловч орон нутагт төрийн байгууллагын орон тоо буураагүй байна.

¹⁸ төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргын 15 хувиас, бусад төв байгууллагын удирдлагын 20 хувиас, яамдын газар, хэлтсийн даргын 30 хувиас, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 40 хувиас доошгүй байх

¹⁹ 10.1.4.төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд 40:60 гэсэн харьцааг хангах бодлого, арга хэмжээг тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх бөгөөд энэ хуулийн 6.5.6-д заасан тохиолдолд энэ заалт үл хамаарна.

Хэдийгээр төрийн байгууллагын үзүүлж буй үйлчилгээ цахимжсан гэх боловч хэрэгжүүлэх чиг үүргийн хувьд өөрчлөлт ороогүй буюу цахим системд мэдээллийг цаасан хэлбэрээр оруулах ажлыг гүйцэтгэсэн хэвээр байна.

2.2.2 Төрийн байгууллагын хүний нөөцийн дутагдалтай байдлаас шалтгаалан төрийн үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэх нөхцөл бүрдээгүй байна.

2.3. Төрийн байгууллагаас гаргаж буй зарим шийдвэрүүд нь уялдаа холбоогүй байна.

2.3.1 Боловсролын салбарт суралцагчийн тооноос хамааруулж тогтоосон жишиг нормоор Баянтал сумын сургууль, цэцэрлэгт нягтлан бодогчийн орон тоо батлагдаагүй бөгөөд дээрх байгууллагад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээг хэн хэрхэн үзүүлэх талаар ямар нэг зохицуулалт байхгүй чиг үүрэг нь орхигдсон байна. Тухайлбал:

- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2024 оны А/85, А/34 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Орон тооны жишиг норматив батлах тухай” тушаалд 3 бүлэгтэй цэцэрлэг орон тооны нягтлан бодогчгүй байхаар тусгасан.
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив”-т 1-9 дүгээр, 6-9 дүгээр анги 160-1500 хүртэл суралцагчтай дунд сургуульд орон тооны нягтлан бодогчгүй байхаар тусгасан. Мөн Уг журмын 6 дугаар зүйлд 8001-ээс дээш хүн амтай сумаас бусад суманд нягтлан бодогчийн үүргийг сумын санхүүгийн алба хариуцан гүйцэтгэнэ гэж заасан боловч Засгийн газрын 2014 оны 326-р тогтоолоор батлагдсан “Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив, 2019 оны 88-р тогтоолын 2.1-т сургууль, цэцэрлэгийн байгууллагад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээг санхүүгийн алба үзүүлэх чиг үүрэг байхгүй байна.

Жишиг нормд шаардлагатай зохицуулалтыг хийж өгөөгүйн улмаас тус сумын сургууль, цэцэрлэг тус тусдаа нягтлан бодогчтой байхаар тушаал гаргаж жишиг нормативыг мөрдөөгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 19 дүгээр 19.3²⁰дахь заалттай нийцэхгүй байгаа бөгөөд хууль журмууд нь хоорондоо зөрчилдөх, нэг нэгнээ үгүйсгэх байдал нийтлэг байгаа тул хуульд нийцүүлэн шийдвэр гаргах шаардлагатай байна. Иймд хуульд нийцүүлэн холбогдох журамд өөрчлөлт оруулах саналыг Үндэсний аудитын газарт уламжлахаар шийдвэрлэв.

Үндэсний аудитын газарт уламжлах санал: "Холбогдох жишиг орон тооны нормативт 1 суманд ажиллаж байгаа 3 бүлэгтэй цэцэрлэг, дунд сургууль дундаа 1 нягтлан бодогч ажиллуулах зохицуулалтыг хийх"

2.3.2 АЗДТГ-ын ХШҮХ-ээс төрийн үйлчилгээний ил тод нээлттэй байдалд хяналт хэрэгжүүлсэн байна.

Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8²¹-т заасан 6 бүлэг 68 зүйл төрлийн мэдээллийг ил тод байршуулах, Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын дагуу зохицуулж байна.

Аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс 2023 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг байршуулсан байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. Хяналт шинжилгээ үнэлгээнд 36 төрийн байгууллагын үйл ажиллагааг хамруулжээ.

²⁰ 19.3.Энэ хуулийн 19.1, 19.2-т зааснаас бусад тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч нь төсвийн ахлах нягтлан бодогч, нягтлан бодогчтой байна.

²¹ Нээлттэй мэдээлэл

Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ

Хүснэгт №10

Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ.	2.Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ.	3.Шударга байдлын түвшин -Авилгын эсрэг төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт, -Тушаал, шийдвэр.
86.7	73.8	90.2	87.6

(Эх сурвалж: АЗДТГ-ын ХШҮХ-ийн тайлан, аудитын тулган баталгаажуулалт)

Хүснэгтээс харахад байгууллагын ил тод байдлын үнэлгээ 86.7 хувьтай байгаа боловч Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар нээлттэй байршуулахаар заасан мэдээллийг аймгийн хэмжээнд 73.8 хувьтай байршуулсан байна. ЦСҮТ ОНӨҮГ, Сум дундын ойн анги, Говьсүмбэр аймгийн Авто тээврийн төв, Политехникийн коллеж 0 үнэлэгдсэн байна.

2.3.3 Орон нутагт авлигын индексийн талаар мэдээлэл байхгүй байна.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 60.2 сая төгрөгийн 8 зөрчил илрүүлж, 60.2 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 2 зөвлөмж, Үндэсний аудитын газарт уламжлах 5 саналыг хүргүүллээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, хууль эрх зүйг хэрэгжүүлэх тогтолцоо бүрэн бүрдээгүй байна.
2. Говьсүмбэр аймгийн төрийн байгууллагуудын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц нь урт, дунд хугацааны бодлогын зорилтыг хангахад чиглэгдсэн байна
3. Төрийн байгууллагын хүний нөөцийн хүрэлцээгүй байдал нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлж байна.
4. Томилох эрх бүхий албан тушаалтнууд 4 албан тушаалд сул орон тооны зарыг тухай бүр хүргүүлээгүй, хуульд заасан шалгуурыг хангаагүй 4 хууль бус томилгоо хийсэн байна.
5. Төрийн байгууллагын хүний нөөцийн тогтолцоо сайн засаглалыг дэмжихэд чиглэгдсэн боловч хэрэгжилт, үр дүн нь хангалтгүй байна.
6. Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх үр дүнтэй тогтолцоо бүрдээгүй байна.
7. Иргэд төрийн үйлчилгээг орон зайнаас үл хамааран цахимаар авах нөхцөл боломж бүрдсэн байна.
8. Төрийн байгууллагаас гаргаж буй зарим шийдвэрүүд нь уялдаа холбоогүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Т.Бат-эрдэнэд:

1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүргийн дагуу аймгийн хэмжээнд төрийн албан хаагчийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулах
2. Төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалтад ороогүй, тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангаагүй байхад хууль тогтоомж зөрчиж зөрчилтэй томилгоо хийхгүй байх

Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь зөвлөлийн дарга Д.Содномд:

1. Төрийн байгууллагууд сул орон тооны зарыг үнэн зөв мэдээлсэн эсэх, томилох эрх бүхий этгээд албан тушаалын томилгоог хууль тогтоомжийн дагуу хийгдэж буй эсэхэд хяналт хэрэгжүүлж үр дүнг тайлагнах

Аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор биелүүлж, хэрэгжилтийг ирүүлэх

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлэх талаар холбогдох газарт уламжлуулах саналтай байна. Үүнд:

1. "Төрд учруулсан хохирлын талаарх цахим мэдээллийн сан үүсгэж хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх" зөвлөмжийг **Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх**
2. "Төрийн байгууллагын хүний нөөцийн цахим системээс мэдээллийг татаж авах, орон нутгийн хэмжээнд нэгтгэх, бүрэлдэхүүн хөдөлгөөн тайланг цахим системээр гаргах эрхийг төрийн албаны салбар зөвлөлд өгөх" зөвлөмжийг **Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх**
3. "Төрийн албаны хүний нөөцийн бүртгэлийг орон нутагт цахимжуулах, нэгдсэн мэдээллийн сантай болгох, нотлох баримтад үндэслэн бүртгэх зэргээр үр дүнтэй хэрэгжүүлэх, нөөц бүрдүүлэх журамд нэмэлт өөрчлөлт оруулах" зөвлөмжийг **Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх**
4. "Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад улсын төсвөөс суралцсан боловч эрх, үүргээ биелүүлээгүй албан хаагчдын сургалтын төлбөрийг буцаан төлүүлэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох" зөвлөмжийг **Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх**
5. Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2024 оны А/85, А/34 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Орон тооны жишиг норматив батлах тухай" тушаалд 3 бүлэгтэй цэцэрлэг орон тооны нягтлан бодогчгүй байхаар тусгасан. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив"-т 1-9 дүгээр, 6-9 дүгээр анги 160-1500 хүртэл суралцагчтай дунд сургуульд орон тооны нягтлан бодогчгүй байхаар тусгасан тул "Холбогдох жишиг орон тооны нормативд 1 суманд ажиллаж байгаа 3 бүлэгтэй цэцэрлэг, дунд сургууль дундаа 1 нягтлан бодогч ажиллуулах зохицуулалтыг хийх" зөвлөмжийг **Боловсролын яаманд хүргүүлэх**

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Найрамдал хотхон, 3 дугаар баг,
Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42015
Утас/Факс: (976) 7054 3118,
Цахим шуудан: zdtg.gsa@gmail.com,
Цахим хуудас: www.govisumber.gov.mn

Аодч. 11.21 № 05/1150

танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.САРАНТУЯА ТАНАА

“Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого,
тогтолцооны үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын
тайлангийн төсөлд өгөх саналгүй болно.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ОТГОНЧИМЭГ



Ахлах аудитор
Б. Дарханбалар
Бүтэцтэй тайлан
Саналт тусгах
тайланг багас-
гаснуудал
4282401332
Өмнөд 12



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/23.

Чойр

Аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9, 18.10 дахь заалт, “Эрх шилжүүлэх тухай” 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь салбар зөвлөл, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Б.Дарханбат)-д даалгасугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилган, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь салбар зөвлөл, аймгийн Засаг даргад зөвлөсүгэй.

4. Аудитын зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор (Б.Дарханбат)-д үүрэг болгосугай.

5. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Б.Дарханбат, аудитор С.Батцэцэг)-т даалгасугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Г.Наранбаяр)-т даалгасугай.



Б.САРАНТУЯА

D:\DOTOOD AJIL\TUSHAAL.doc

008910113